



**НИЙСЛЭЛИЙН  
СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/45.

Улаанбаатар хот

“Олон улсын сурагч солилцоо-2019”-нд оролцогчдод зориулсан бэсрэг наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2019 оны зорилт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/105 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас жил бүр зохион байгуулдаг “Олон улсын сурагч солилцоо-2019”-ны хөтөлбөрт оролцогчдод зориулсан бэсрэг наадмыг 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсугай.

2. “Олон улсын сурагч солилцоо-2019” хөтөлбөрт оролцогчдод зориулсан бэсрэг наадмыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 650.000 /Зургаан зуун тавин мянган/ төгрөгийг “Олон улсын сурагч солилцоо-2019” хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас манай байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Спортын хөгжлийн хэлтэс /С.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД

1150500140

Нийслэлийн Спорты хорооны даргын 2019 оны  
 07 сүүлээр .....сарын 22-ны  
 өдрийн 27/45 дугаар тушаалын хавсралт



СУРАГЧ СОЛИЛЦООНЫ БЭСРЭГ НААДАМ

№	Зохион байгуулах арга хэмжээний нэр	Зардлын хэмжээ
<b>Үндэсний сурын харваа</b>		
1.	1-р байр /2 хүүхэд эрэгтэй, эмэгтэй/	40.000
2.	2-р байр /2 хүүхэд эрэгтэй, эмэгтэй/	30.000
3.	3-р байр /2 хүүхэд эрэгтэй, эмэгтэй/	20.000
4.	4-р байр /2 хүүхэд эрэгтэй, эмэгтэй/	20.000
5.	Шүүгч /2 хүн х40.000 төг/	80.000
Дүн		190.000
<b>Үндэсний бөхийн барилдаан</b>		
1.	Түрүүлсэн бөх 1	40.000
2.	Үзүүрлэсэн бөх 1	30.000
3.	Их шөвөг /2 хүүхэд х20.000 төг/	40.000
4.	Дунд шөвөг /2 хүүхэд х15.000 төг/	30.000
5.	Бага шөвөг /2 хүүхэд х10.000 төг/	20.000
6.	Засуулын урамшуулал /2 хүн х40.000 төг/	80.000
Дүн		240.000
<b>Шагайн харваа</b>		
1.	1-р байр /2 хүүхэд х20.000 төг/	40.000
2.	2-р байр /2 хүүхэд х15.000 төг/	30.000
3.	3-р байр /2 хүүхэд х10.000 төг/	20.000
4.	Шүүгч /2 хүн х40.000 төг/	80.000
5.	Унааны зардал	50.000
Дүн		220.000
Нийт дүн		650.000